

НИСЭХИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2021.10.04

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Алтанцомын баталсан 2021 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн ИНҮТ-ийн харьяа Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албаны үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай 19/21 тоот удирдамжийн хүрээнд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны аудитор Т.Саранчимэг, О.Сэндэр, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Б.Болормаа, Ж.Нямдэлгэр нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрөөс 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийг дуустал хугацаанд дотоод аудит, хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэсэн.

2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний бүрэн хэрэгжээгүй ажлыг 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан ч 2021 оны 3 дугаар улирлын байдлаар хэрэгжээгүй байна. Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 217 дугаар тогтоол “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын 4.7.-д заасны дагуу ИНҮТ нь НМҮА-ны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хянаагүй, хагас жилээр үнэлээгүй байна.

НМҮА-ын байгуулсан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хамтран ажиллах 11 гэрээнээс 10 гэрээний дуусах хугацаа тодорхойгүй, гэрээний зүйл заалтыг алдсан, үсэг хоорондын зай алдагдсан, Иргэний хуулийн 48 дугаар бүлгийн 476-480 дугаар зүйлийг мөрдөөгүй, “Иргэний нисэхийн ерөнхий газарт гэрээ байгуулах журам”-ын дагуу гэрээг байгуулаагүй.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 206 дугаар тогтоол “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу даргын тушаалын шийдвэрийн зүйл, заалт, үүрэг болгосон тухайн нэгж бүрээр Иргэний нисэхийн үндэсний төвөөс үнэлдэггүй, улирал бүр даргын тушаалын биелэлтийн тайлан гаргадаггүй, хэрэгжилт удаашралтай тушаалыг хяналтандаа авч хариу арга хэмжээ авах дүгнэлт, зөвлөмж өгдөггүй.

Албаны зарим ажилтнууд ИНЕГ-ын “Хөдөлмөрийн дотоод журам”, “Иргэний нисэхийн ерөнхий газрын ажилтны ёс зүйн дүрэм”-ийг зөрчиж ажлын байранд биеийн тамирын хувцас, жинс, пүүз өмсөж байна. ИНЕГ-ын даргын 2017 оны А/534 дүгээр тушаалаар тус албаны ээлжийн ажилтнуудад 2 жил тутамд дүрэмт хувцас олгохоор норм баталсан. 2019 оны 12 сард дүрэмт хувцас олгосон ч зарим ажилтнууд нормын хувцсаа өмсдөггүй.

Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2021 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан “Зайнаас ажиллах үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг зөрчиж зайнаас ажилласан 26 ажилтанд хоолны мөнгө, үр дүнгийн нэмэгдэл хөлсийг илүү олгосон байна.

Ажилтны ажлын байранд ажилласан цаг болон ажилтны ирцийн бүртгэл хоорондоо зөрүүтэй, ажилтны ажлын байранд ажилласан цагийг нэгтгэн тооцоход цагийн баланстаа хүрэхгүй байхад илүү цагийн хөлс олгосон байна.

Veritech ERP программын Хүний нөөцийн удирдлагын Ажилтны бүртгэлд ажилтны шилжилт хөдөлгөөнтэй холбоотой 1 тушаалыг 2 удаа бүртгэсэн, тушаалын огноог буруу

бүртгэснээс ажилтны ажилласан жил буруу тооцогдож, үүнээс үүдэн амралтын хоног, удаан жил, ХЧТА тэтгэмж буруу бодогдох эрсдэлтэй байна.

Албаны ажиллагсдад 2021 оны эхний 8 сарын байдлаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-т заасан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явагдаагүй байна.

ИНЕГ-ын даргын 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/688 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр үзлэг, гурван шатны хяналтыг зохион байгуулах журам”-д заасан хугацаанд нэг дэх болон хоёр дахь шатны хяналтыг явуулаагүй байна.

Дотоод аудитын албанаас Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албаны үйл ажиллагаанд 2020 онд хийсэн дотоод аудит, хяналт шалгалтын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 85.6 хувьтай байна.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар Иргэний нисэхийн үндэсний төвд 4, тус албанд 13, нийт 17 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА